



I-III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13




## Улсын хэмжээнд 67.2 мянган толгой мал хорогдсон байна

Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 30.8 сая хээлтэгч малын 8.4 сая (27.3%) нь 2022 оны эхний улиралд төллөсөн байна. Эм хонины 30.3 хувь, эм ямааны 30.3 хувь, ингэний 10.4 хувь, үнээний 6.3 хувь, гүүний 2.2 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.1 хувь буюу 8.3 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 2.5 (42.9%) саяар өссөн байна.

ЗУРАГ 1. ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр, хувиар, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар



Том малын зүй бус хорогдол 2022 оны эхний улиралд улсын хэмжээнд 67.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 981.4 (93.6%) мянгаар буурсан байна. Харин 2022 оны 3 дугаар сард 34.9 мянган мал хорогдсон нь эхний улиралд хорогдсон малын 51.9 хувийг эзэлж байгаа бол 2 дугаар сард хорогдсон малаас 13.7 (64.3%) мянгаар өссөн байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 28.4 мянга, хонь 27.5 мянга, үхэр 6.8 мянга, адуу 4.4 мянга, тэмээ 73-аар хорогдсон байна. Нийт хорогдсон малын 42.3 хувийг ямаа, 40.9 хувийг хонь эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2019 I-III	2020 I-III	2021 I-III	2022 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III	2022 I-III
	мянган толгой				хувь			
<b>Дүн</b>	<b>295.0</b>	<b>558.0</b>	<b>1 048.6</b>	<b>67.2</b>	<b>0.44</b>	<b>0.79</b>	<b>1.56</b>	<b>0.10</b>
Адуу	13.0	21.6	41.2	4.4	0.33	0.51	1.01	0.10
Үхэр	24.9	39.9	74.7	6.8	0.57	0.84	1.58	0.14
Тэмээ	0.3	0.2	6.3	0.1	0.06	0.04	1.33	0.02
Хонь	112.6	278.5	348.3	27.5	0.37	0.86	1.16	0.09
Ямаа	144.2	217.9	578.1	28.4	0.53	0.74	2.09	0.11

2022 оны эхний улиралд Архангай аймагт 11.3 (16.8%) мянга, Хэнтий аймагт 7.6 (11.3%) мянга, Ховд аймагт 6.3 (9.4%) мянга, Хөвсгөл аймагт 6.3 (9.3%) мянга, Баян-Өлгий аймагт 5.8 (8.6%) мянган мал хорогдсон нь нийт хорогдлын 55.4 хувийг эзэлж байна.


ЗУРАГ 1. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, аймаг, нийслэлээр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар, мянган толгой



Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон 30.8 сая эх малын 14.6 мянга (0.05%) нь энэ оны эхний улиралд хорогдсон байна. Увс, Сүхбаатар, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Архангай аймагт хээлтэгч мал 1.1-2.5 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 65.5 хувийг эзэлж байна. Харин 1.9 мянган хээлтүүлэгч хорогдсоноос ухна 950, хуц 545, бух 289, азарга 92, буур 2 тус тус байна.

Улсын хэмжээнд 2022 оны эхний улиралд 3.3 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.1 (49.2%) мянгаар өссөн байна.

ЗУРАГ 3. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар, дүнд эзлэх хувиар



Хорогдсон нийт том малын 93.3 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгаанаар хорогдсон бол 1.8 хувь нь аюулт үзэгдлээр, 4.9 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

## Ойлголт, тодорхойлолт

**Том малын зүй бус хорогдол:** Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

**Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь:** Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

**Бэлэн хээлтэгч:** Малын төрөл бүр дэх нас гүйцсэн эм малыг хамруулна.



## Эх үүсвэр:

ҮСХ, Том малын зүй бус хорогдлын мэдээ

## Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

## Дараагийн мэдээ гархаах хуваарь:

2022 оны 5 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Э.Болормаа  
Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212